



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2014 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Нэрийн дансны 2013 оны орлогод тооцох
хүүгийн хэмжээг тогтоох тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.7 дугаар заалт, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Үндэсний статистикийн хорооны 2014 оны 01/507 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2013 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 22.3 хувиар тогтоосугай.

Хоёр. Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Уртнасан)-т ДААЛГАХ нь:

1/ Баталсан хүүгийн хэмжээг үндэслэн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2013 оны орлогод хүү тооцох ажлыг 2014 оны 3 дугаар улиралд багтаан хэрэгжүүлэх;

2/ Нэрийн дансны мэдээлэх хуудсыг даатгуулагчдад 2014 оны 4 дүгээр улиралд багтаан мэдээлэх ажлыг зохион байгуулах;

Гурав. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (М.Саранчимэг)-нд даалгасугай.

ДАРГА



С.ЭРДЭНЭ